



6 Нэг үетэй үгийг олж будаарай.

тэг	өрөө	туулай	сайхан	вирус	хот
зараа	даам	хүйтэн	ноос	тоглох	бичих
цэцэг	хуур	бар	цааган	бэлэг	ярих
буйдан	шатар	сандаг	тоорцог	олз	амрах

7 Цэгийн оронд хаалтад байгаа үгсээс сонгон өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

( сорьё , урья , харья , тарья , тарья , харья )

- ✓ Анарыг төрсөн өдөртөө .....
- ✓ Хичээлээ тараад гэртээ .....
- ✓ Тоо бодож оюунаа .....
- ✓ Алсын уулсыг .....
- ✓ Бүгдээрээ мод .....
- ✓ Ажлаа дуусаад .....

8 Цэгийн оронд тохирох үгийг бичиж, өгүүлбэрийг гүйцээгээрэй.

А. Өвөө үлгэр ..... ярив. \ туйл , тууль \

Б. .... голын хөвөөгөөр модод ургасан байв. \ Туйл , Туул \

В. Нүүхдээ гэрийн ..... сайн цэвэрлэх хэрэгтэй. \ буйраа , бууриа \

Г. .... дүрмээ сайн баримтлаарай. \ Хуйл , Хууль \

9 Балархай эгшиг нь ямар үүрэгтэй вэ? Зөв харгалзуулаарай.

тарив, сорив, танил, гурил, ахин

Дан зөөлрүүлэх үүрэгтэй

салхи, горхи, тархи, гархи, анги

Давхар зөөлрүүлэх үүрэгтэй

10 Эцэг эхчүүдэд зориулсан зөвлөгөөг зурагтай зөв харгалзуулаарай.



- Хүүхдийн гар хүрэх газарт шүдэнз, асаагуур, хутга, заазуур, хайч зэрэг хурц ирмэгтэй зүйл байрлуулж болохгүй.

- Стандартын шаардлага хангасан цахилгааны утас, уртасгагч, залгуур зэргийг хэрэглээрэй.
- Хоолны сав, тогооны бариулыг плитка, зуухны ар тал руу харуулбал сайн.
- Халуун тогоо ашиглаж буй тохиолдолд хүүхдийн гар хүрэхгүй газарт байрлуулаарай.

- Цонх, тагт, салхивчид зориулалтын түгжээ хийвэл сайн.
- Цонх, тагтны дэргэд хүүхэд авирах боломжтой ор болон эд зүйлийг байрлуулахгүй байх нь тохиромжтой.

- Гэрийн орчинд зуух, пийшин ашигладаг бол тусгаарлалт, хамгаалалт хийгээрэй.
- Хэрэв хийн түлш, газ ашигладаг бол мэдрэгч, дохиолол ашиглах хэрэгтэй.
- Галын аюулгүй байдлыг бүрэн хангаарай.